



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Яруу сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2022/110/СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улиастай хот

2022 он

Төрийн аудитын газрын  
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа  
Утас: 99993365

Цахим хаяг: [bat-undraad@audit.gov.mn](mailto:bat-undraad@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Дагвасүрэн

Утас: 99014227

Цахим хаяг: [dagvasurend@audit.gov.mn](mailto:dagvasurend@audit.gov.mn)

Аудитор: Г.Баасанжаргал

Утас: 99032514

Цахим хаяг: [baasanjargalg@audit.gov.mn](mailto:baasanjargalg@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал .....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	11
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт .....	12
4.2.1 Залруулсан алдаа .....	12
4.2 .2 Төлбөрийн акт .....	12
4.2.3 Албан шаардлага .....	12
4.2.4 Зөвлөмж.....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12

2022.02.24 № 1302/318

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ЯРУУ СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА М.АРИУНЖАРГАЛ-д

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Яруу сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Яруу сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

013025311

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>25011423.07</b>	<b>62096854.05</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	0.00	2614258.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	0.00	2614258.00
31211	Төрийн сангийн харилцах	0.00	1089915.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	1524343.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	3377354.90	20238833.88
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	91025.02	0.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0.00	14784000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	3286329.88	5454833.88
3351	Байгууллагаас авах авлага	2206329.88	4195833.88
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1080000.00	1259000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	21634068.17	39243762.17
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	7963479.37	23636569.37
35110	Тусгай зориулалттай материал	468000.00	468000.00
35130	Эм боох материал	7495479.37	23168569.37
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	13670588.80	15607192.80
35410	Бичиг хэргийн материал	0.00	1195750.00
35420	Аж ахуйн материал	5482419.80	6940469.80
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	118300.00
35440	Түлш, шатах тослох материал	4000000.00	660000.00
35460	Хүнсний материал	877900.00	1704500.00
35470	Бусад хангамжийн материал	3310269.00	4988173.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>177549507.03</b>	<b>223346107.18</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	177549507.03	223346107.18
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	171520707.03	217317307.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	148127123.00	144200103.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-7024880.32	-7713100.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	36730000.00	36730000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-23870000.44	-30790000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	47438955.50	110373743.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	-37302101.11	-42294045.32
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17224656.00	17564656.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12103545.26	-13405008.38
39214	Бусад үндсэн хөрөнгө	4616000.00	5150500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2315500.34	-2499540.38
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	6028800.00	6028800.00
39301	Програм хангамж	815000.00	815000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-815000.00	-815000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6028800.00	6028800.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>202560930.10</b>	<b>285442961.23</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>180193.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	0.00	180193.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	0.00	180193.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	180193.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>202560930.10</b>	<b>285262768.23</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	202560930.10	285262768.23
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	109366580.93	109366580.93
51101	Өмч: - төрийн	109366580.93	109366580.93
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-70861808.83	11840029.30
51210	Өмнөх үеийн үр дүн	-57776635.94	-70861808.83
51220	Тайланг үеийн үр дүн	-13085172.89	82701838.13
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	164056158.00	164056158.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>202560930.10</b>	<b>285442961.23</b>

**Яруу сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>358258819.37</b>	<b>537597450.56</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>305342379.37</b>	<b>414652240.56</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3406279.37	71315140.56
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3406279.37	71315140.56
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3406279.37	71315140.56
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	301936100.00	343337100.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	301936100.00	343337100.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>52916440.00</b>	<b>108161210.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	35764000.00	9698900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	9653200.00	9698900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлдгээс санхүүжих	26110800.00	0.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	29900000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	29900000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	0.00	14784000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	17152440.00	68562310.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	17152440.00	68562310.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>371343992.26</b>	<b>452890717.19</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>371343992.26</b>	<b>452890717.19</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	365960868.26	425897579.19
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	234354663.00	277131907.02
210101	Үндсэн цалин	203519603.00	218830675.02
210102	Нэмэгдэл	16969727.00	39568226.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2048000.00	0.00
210104	Урамшуулал	11817333.00	18733006.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29703027.82	35728812.00
210201	Тэтгэврийн даатгал	19843536.00	26381639.00
210202	Тэтгэмжийн даатгал	3234607.82	2386358.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1867627.00	1971125.00
210204	Ажилгүйдлийн даатгал	432477.00	453609.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4324780.00	4536081.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	11069341.00	5509762.00
210301	Гэрэл, цахилгаан	1362641.00	1235762.00
210302	Түлш, халаалт	9581000.00	4162000.00
210303	Цэвэр, бохир ус	125700.00	112000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17844210.00	25817000.00
210401	Бичиг хэрэг	1244100.00	1262700.00
210402	Тээвэр, шатахуун	14508100.00	21228800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1465400.00	1306800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	173610.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	453000.00	2018700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	29618680.00	40929525.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24352000.00	33973925.00
210502	Хоол, хунс	5266680.00	6955600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1118000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	320000.00	0.00
210604	Урсгал засвар	798000.00	0.00
<b>2107</b>	<b>Төмилөлт, зочны зардал</b>	959000.00	1632000.00
210702	Дотоод албан төмилөлт	959000.00	1632000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	16057970.00	15471470.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15658070.00	14902560.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	210000.00	210000.00
210803	Даатгалын үйлчилгээ	70000.00	70000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48100.00	68000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	14800.00	14800.00
210807	Газрын төлбөр	50000.00	50000.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7000.00	5110.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	151000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	25235976.44	23677103.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11173410.00	7669311.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14062566.44	16007792.17
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	5383124.00	26993138.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	0.00	26970000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	26970000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	5383124.00	23138.00
213303	Төвлөрүүлдэх шилжүүлэг	5383124.00	23138.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-13085172.89</b>	<b>84706733.37</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	0.00	2004895.24
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	2004895.24
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	0.00	-2004895.24
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-13085172.89</b>	<b>82701838.13</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	109,366,580.93	164,056,158.00	-57,776,635.94	0.00	215,646,102.99
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	109,366,580.93	164,056,158.00	-57,776,635.94	0.00	215,646,102.99
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	-13,085,172.89	0.00	-13,085,172.89
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	109,366,580.93	164,056,158.00	-70,861,808.83	0.00	202,560,930.10
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	109,366,580.93	164,056,158.00	-70,861,808.83	0.00	202,560,930.10
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	109,366,580.93	164,056,158.00	-70,861,808.83	0.00	202,560,930.10
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	109,366,580.93	164,056,158.00	-70,861,808.83	0.00	202,560,930.10
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	82,701,838.13	0.00	82,701,838.13
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	109,366,580.93	164,056,158.00	11,840,029.30	0.00	285,262,768.23

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>354852540.00</b>	<b>451498310.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>301936100.00</b>	<b>343337100.00</b>
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	301936100.00	343337100.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	301936100.00	343337100.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>52916440.00</b>	<b>108161210.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	35764000.00	9698900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	9653200.00	9698900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	26110800.00	0.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	29900000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	29900000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	17152440.00	68562310.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	17152440.00	68562310.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>354852540.00</b>	<b>441091052.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>354852540.00</b>	<b>441091052.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>349469416.00</b>	<b>413897914.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	234358290.00	282409075.00
210101	Үндсэн цалин	160253933.00	142630160.00
210102	Нэмэгдэл	56117711.00	89328249.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3790000.00	4044288.00
210104	Урамшуулал	14196646.00	46406378.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29801424.00	30932230.00
210201	Тэтгэврийн даатгал	20739424.00	20605630.00
210202	Тэтгэмжийн даатгал	2265500.00	2581700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1812400.00	2065300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	453100.00	516300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4531000.00	5163300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	8854341.00	8599762.00
210301	Гэрэл, цахилгаан	1362641.00	1235762.00
210302	Түлш, халаалт	7366000.00	7252000.00
210303	Цэвэр, бохир ус	125700.00	112000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	18897310.00	22158100.00
210401	Бичиг хэрэг	1244100.00	2268600.00
210402	Тээвэр, шатахуун	14295100.00	16396500.00
210403	Шуудан, холбоо, ингернэтийн төлбөр	1465400.00	1306800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	430400.00	645200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1462310.00	1541000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	27852671.00	43878462.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22473071.00	32926185.00
210502	Хоол, хүнс	5043600.00	9276277.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	336000.00	1676000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1515000.00	1791500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	397000.00	600000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	320000.00	344500.00
210604	Урсгал засвар	798000.00	847000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	959000.00	1632000.00
210702	Дотоод албан томилолт	959000.00	1632000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	16057970.00	15471470.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15658070.00	14902560.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	210000.00	210000.00
210803	Даатгалын үйлчилгээ	70000.00	70000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48100.00	68000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	14800.00	14800.00
210807	Газрын төлбөр	50000.00	50000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7000.00	5110.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	151000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	11173410.00	7025315.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11173410.00	7025315.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5383124.00</b>	<b>27193138.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	0.00	27170000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	27170000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	5383124.00	23138.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5383124.00	23138.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>0.00</b>	<b>10407258.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>0.00</b>	<b>7793000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>7793000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	0.00	7793000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	7793000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>0.00</b>	<b>-7793000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	0.00	2614258.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	0.00	2614258.00

**Яруу сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	331964600.00	326484415.00	373618000.00	372267847.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	331964600.00	326484415.00	373618000.00	372267847.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	331964600.00	326484415.00	373000500.00	371697847.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	228149400.00	228358290.00	258166800.00	262086970.00
210101	Үндсэн цалин	151827900.00	154253933.00	155427900.00	142630160.00
210102	Нэмэгдэл	56645800.00	56117711.00	74605400.00	89328249.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5016000.00	3790000.00	4807000.00	4044288.00
210104	Урамшуулал	14659700.00	14196646.00	23326500.00	26084273.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30784200.00	29801424.00	34852500.00	30932230.00
210201	Тэтгэврийн даатгал	21722200.00	20739424.00	24525800.00	20605630.00
210202	Тэтгэмжийн даатгал	2265500.00	2265500.00	2581700.00	2581700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1812400.00	1812400.00	2065400.00	2065300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	453100.00	453100.00	516300.00	516300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4531000.00	4531000.00	5163300.00	5163300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	8844600.00	8854341.00	9636400.00	8599762.00
210301	Гэрэл, цахилгаан	1352400.00	1362641.00	1352400.00	1235762.00
210302	Түлш, халаалт	7366500.00	7366000.00	8157900.00	7252000.00
210303	Цэвэр, бохир ус	125700.00	125700.00	126100.00	112000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20951300.00	18897310.00	22405200.00	22070700.00
210401	Бичиг хэрэг	1806200.00	1244100.00	2181600.00	2181200.00
210402	Тээвэр, шатахуун	15427900.00	14295100.00	16506400.00	16396500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1680000.00	1465400.00	1680000.00	1306800.00
210404	Ном, хэвлэл	60000.00	0.00	60000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	645200.00	430400.00	645200.00	645200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1332000.00	1462310.00	1332000.00	1541000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	14123300.00	12028870.00	21519900.00	21513800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7440000.00	6649270.00	14836600.00	13414623.00
210502	Хоол, хүнс	5006800.00	5043600.00	5006800.00	6423177.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1676500.00	336000.00	1676500.00	1676000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1915800.00	1515000.00	1413700.00	1791500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	818800.00	397000.00	818800.00	600000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	344500.00	320000.00	344500.00	344500.00
210604	Урсгал засвар	752500.00	798000.00	250400.00	847000.00
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	997800.00	959000.00	1398000.00	1393500.00
210702	Дотоод албан томилолт	997800.00	959000.00	1398000.00	1393500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	15549000.00	16057970.00	15999000.00	15471470.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15091200.00	15658070.00	15091200.00	14902560.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	210000.00	210000.00	210000.00	210000.00
210803	Даатгалын үйлчилгээ	70000.00	70000.00	70000.00	70000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68000.00	48100.00	68000.00	68000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	14800.00	14800.00	14800.00	14800.00
210807	Газрын төлбөр	50000.00	50000.00	50000.00	50000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	45000.00	7000.00	45000.00	5110.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	0.00	45000.00	151000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	10649200.00	10012210.00	7609000.00	7837915.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10649200.00	10012210.00	7609000.00	7837915.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	0.00	0.00	617500.00	570000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	0.00	0.00	617500.00	570000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	0.00	617500.00	570000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	9597100.00	9653200.00	9636300.00	9698900.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	9597100.00	9653200.00	9636300.00	9698900.00
122005	Орон нутгийн төсвөөс	9597100.00	9653200.00	9636300.00	9698900.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>1113053.00</b>
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>20.00</b>	<b>20.00</b>	<b>20.00</b>	<b>20.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>19.00</b>	<b>19.00</b>	<b>19.00</b>	<b>19.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	16.00	16.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00	2.00	2.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	76593067.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	76593067.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	49993067.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	20322105.00
210104	Урамшуулал	-	20,322,105.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	87400.00
210401	Бичиг хэрэг	-	87,400.00
2105	Нормативт зардал	0.00	22364662.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	19,511,562.00
210502	Хоол, хүнс	-	2,853,100.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	238500.00
210702	Дотоод албан томилолт	-	238,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	6980400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	6,980,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	26600000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	26600000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	26,600,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	29900000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	29900000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	29,900,000.00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Яруу сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Г.Баасанжаргал гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Яруу сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Яруу сумын Эрүүл мэндийн төвийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар товч тодорхойллоо. Үүнд:

Ард иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг тухай бүрт нь чанартай жигд хүртээмжтэй хүргэж эрүүл амьдралыг бэлэглэнэ.

Чиг үүрэг: Эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Яруу сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 537,597.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,063.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,047.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		2,614.20	2,614.2
Авлага	3,377.3	20,238.8	16,861.5
Бараа материал	21,634.1	39,243.8	17,609.7
Үндсэн хөрөнгө	177,549.5	223,346.1	45,796.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>202,560.9</b>	<b>285,442.9</b>	<b>82,882.0</b>
Өр төлбөр	-	180.2	180.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	202,560.9	285,262.7	82,701.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>202,560.9</b>	<b>285,442.9</b>	<b>82,882.0</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,614.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд харилцах дансанд үлдэгдэл төвлөрүүлэх шийдвэр гарсан байна.

Авлага дансны үлдэгдэл 16,861.5 мянган төгрөгөөр өссөн нийгмийн даатгалын сангийн авлага болон бусад байгууллагаас авах авлагатай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 17,609.7 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар ирсэн эм боох материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 45,796.6 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар ирсэн тоног төхөөрөмж болон бусад хөрөнгө, хуримтлагдсан элэгдлийн зардалтай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 180.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд ажилчидтай холбоотой ХАОАТ-ын өглөг үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 82,701.8 мянган төгрөг болж өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалж байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 373,618.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 373,618.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 343,337.1 мянган төгрөг, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 9,698.9 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас 68,562.3 мянган төгрөг, нэмэлт дансаар 29,900.0 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус авч, урсгал үйл ажиллагаанд 441,091.0 мянган төгрөгийг зарцуулж, 23.1 мянган төгрөгийг улсын төсөвт, 0.00 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 78,117.4 мянган төгрөгийн санхүүжилт авч 6,980.4 мянган төгрөгийг бараа үйлчилгээний зардалд 49,993.1 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 26,600.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

### **3.8 Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн анхан шатны баримтын бүрдүүлэлт сайн, Санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн цагалбар, болон НББ-ийн тухай хууль, Сангийн сайдын 388 дугаар тушаалын дагуу бэлтгэсэн байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Төсвийн тухай хууль болон НББ-ийн тухай хууль бусад заавар журмыг дагаж мөрдсөн байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 146 мэдээлэл, хугацаа хоцроосон 3 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ хэсэгт 113,738,805.00 төгрөгийн орлого, 32,926,185.00 төгрөгийн зарлага, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 20,238,833.88 төгрөгийн авлага болон төсөв зарцуулахтай холбоотой шийдвэрийг мэдээлээгүй, өмнөх онд өгөгдсөн шилэн данстай холбоотой зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн “шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалттай нийцэхгүй байна” гэж дүгнэлээ.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар авлагыг барагдуулах зөвлөмж өгснийг тайлант онд барагдуулан ажилласан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар нярвын нэрийн дансанд төсвийн мөнгө төвлөрүүлэн, зориулалт бус зарцуулалт гаргасан эсэхийг үзэх.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 206,296.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 13,551.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 9,566.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 заалт бүхий зөвлөмж, 16,275.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоож, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 166,903.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 заалт бүхий албан шаардлага хүргүүлсэн.

### **4.2.1 Залруулсан алдаа**

Санхүүгийн тайлангийн уялдааг 2,361.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн, хөрөнгө оруулалтаар ирсэн хөрөнгийг 3,397.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан, үндсэн хөрөнгийг бичиг хэргийн зардалд тусгасан 7,793.0 мянган төгрөгийг тус тус аудитын явцад залруулсан.

### **4.2.2 Төлбөрийн акт**

Аудитаар эмийн зардлаас “Содон урлахуй” ХХК руу шилжүүлсэн үнийн дүнгийн үндсэн баримтгүй, төлбөрийн хүсэлтгүй, уг компанид шилжүүлсэн мөнгөөр ажилчдад биеийн тамирын хувцас худалдан авч олгосон 1,031.0 мянган төгрөг, хүүхдийн баярт зориулан төсвөөс 460.0 мянган төгрөгөөр бэлэг худалдан авсан, 2021 онд ковидоор өвчилсөн иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлын хэмнэлт буюу тухайн төсвийн жилд ашиглагдаагүй үлдэгдэл 14,784.0 мянган төгрөгийг төсвийн дараагийн жилд үргэлжлүүлэн зарцуулах нөхцөл байдал үүссэн зэрэг зориулалт бус зардлууд гаргасанд төлбөрийн акт тогтоосон.

### **4.2.3 Албан шаардлага**

Аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаагүй 166,903.8 мянган төгрөгний албан шаардлага хүргүүлсэн.

### **4.2.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 НББ, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

1,422.0 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй бөгөөд ангилал, үнэлгээ ба хуваарилалт зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зарцуулахдаа Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг баримтлан ажиллаж, эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулахгүй байх.

2 Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Харилцагч байгууллага болон иргэнээс худалдан авсан и-баримтын 6,556.1 мянган төгрөгийг бүрдүүлээгүй нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтуудтай нийцэхгүй бөгөөд иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ"; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах;

3 НББ, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тээвэр шатахууны зарцуулалтын баримтууд дутуу, жолоочийн замын тооцооны хуудас нь зарцуулсан шатахуунтай зөрүүтэй, автомашины шатахуун зарцуулалтын жишиг нормыг дагаж мөрдөөгүй 1,588.2 мянган төгрөгний зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь заалтуудтай нийцэхгүй бөгөөд иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зарцуулахдаа Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6-д Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ" заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтуудыг тус тус мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мян.төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
		10	206,296.4	3	13,551.3	3	16,275.0	1	166,903.8	3	9,566.3
Дүн		10	206,296.4	3	13,551.3	3	16,275.0	1	166,903.8	3	9,566.3
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
Дүн											
Нийт дүн											

**БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:**

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

2022.02.25

АХЛАХ АУДИТОР

Б.ДАГВАСҮРЭН

2022.02.25

**БЭЛТГЭСЭН:**

АУДИТОР

Г.БААСАНЖАРГАЛ

2022.02.25